



АЙМГИЙН ЗДТГ-ЫН  
ДАРГА Ц.ГАНБОЛД ТАНАА

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхэр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.19 № 106  
таний -ны № -т

Г Өөрчлөлтгүй дүгнэлт Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,429,949.5 мянган төгрөг байсан бол 155,895.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 270,939.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй авч, 50,454.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасан 16,140.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлж, оны эцэст 6,790,249.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй болсон.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бараа материалын тайлангийн үлдэгдэл баланс, тодруулга, тооллогын бүртгэлийн үлдэгдлээс зөрүүгүй байсан. Дуусаагүй үйлдвэрлэл оны эхэнд 38,927,960.4 мянган төгрөгийн үлэгдэлтэй байсан бол тайлант онд 30,342,505.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 16,281,442.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн бүртгэж оны эцэст 52,989,023.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

6225020062

D:\Audit\gazar\baiгууллагын dotood barimt\A4

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

О.БАТЖАРГАЛ